



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 12 дугаар сарын 20

Дугаар 14/03

Баян-Өндөр сум


Г “Орон нутгийн түвшинд үндэсний аюулгүй байдлыг хангах хөтөлбөр” батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.8, 48 дугаар зүйлийн 48.1, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай” 48 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Орон нутгийн түвшинд үндэсний аюулгүй байдлыг хангах хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан, шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусган, хэрэгжилтийг зохион байгуулахад нутгийн захиргааны болон холбогдох хууль, хяналтын байгууллагуудыг удирдлага зохион байгуулалтаар хангаж, үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргад үүрэг болгосугай.

3.Хөтөлбөрийн биелэлтийг зорилт нэг бүрээр гаргаж жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан аймгийн ИТХ-ын Зөвлөлд тайлагнахыг аймгийн Засаг даргад даалгасугай.



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны
12 дугаар сарын 20-ны өдрийн Ээлжит бус XIV
хуралдааны 11 дугаар тогтоолын хавсралт

**ОРОН НУТГИЙН ТҮВШИНД ҮНДЭСНИЙ
АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ХӨТӨЛБӨР**

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Аймгийн хэмжээнд Үндэсний аюулгүй байдлыг хангах хөтөлбөрийг Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, “Монгол Улсын Их хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигаар батлагдсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”, Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Орхон аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдийг үндэс болгов.

1.2. Орхон аймаг нь Улаанбаатар хотоос 380 км, Булган аймгаас 68 км, Дархан-Уул аймгаас 180 км зайд оршдог, аймгийн нутаг дэвсгэр нь Баян-Өндөр, Жаргалант сумдад хуваагддаг, нийт 29 /Баян-Өндөр сум 26, Жаргалант сум 3/ багтай. Далайн түвшнээс дээш 1200 метрт өргөгдсөн 84.4 мянган га/кв.м нутаг дэвсгэртэй, 29.3 мянган өрх, 106.2 мянган хүн амтай, газар зүйн байрлалын хувьд Монгол Улсын төв хойд хэсэгт оршдог бөгөөд Сэлэнгэ, Булган аймагтай хил залгаа оршдог онцлогтой. Хүн амын 33.2 хувь нь 0-15 насныхан, 57.8 хувь нь 16-59 насныхан, 9.0 хувь нь 60 ба түүнээс дээш насныхан эзэлдэг. Мөн нийт өрхийн 96.6 хувь, хүн амын 96.8 хувь нь тус тус Баян-Өндөр суманд оршин сууж байна.

1.3. Орхон аймгийн эдийн засгийн голлох салбар нь уул уурхайн олборлох үйлдвэр бөгөөд зэс, молибдений баяжмал, уурхайн тэсэлгээний бодис үйлдвэрлэх болон зэсийн хүдэр бутлах ган бөмбөлгийн үйлдвэр, хүнсний, өнгөт металлын, хивсний зэрэг хөнгөн үйлдвэрүүдтэй. Нийт 5612 аж ахуйн нэгжид 31,9 мянган ажиллаж жилдээ 3,6 их наяд төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгдгээс 90 хувийг нь жилдээ 25,0 сая тонн хүдэр олборлох хүчин чадалтай уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр дангаараа гаргадаг. Үлдсэн 10 орчим хувь нь цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэх болон боловсруулах үйлдвэрт ногдож байна. Эндээс жилдээ 410,3 мянган метр² хивс үйлдвэрлэдэг “Эрдэнэт хивс” ХХК, 9,8 мянган тонн катодын зэс, зэс утсыг Эрдмин ХХК, Ачит Ихт ХХК үйлдвэрлэдэг. Мөн газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг 12 аж ахуйн нэгж 1000 гаруй өрх, иргэн жилд дунджаар 11,5 мянган тонн үр тариа, 3,2 мянган тонн төмс, 7,3 мянган тонн хүнсний ногоо хураан авч, 10,000 гаруй тонн хадлан бэлтгэдэг.

ХОЁР.ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗАРЧИМ, ХУГАЦАА

2.1. Аймгийн хэмжээнд “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Үндэсний аюулгүй байдлын тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах, үндэсний аюулгүй

байдалд хохирол учруулж болзошгүй үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

2.2.Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулахад төрийн нэгдмэл бодлогод нийцүүлэх, шуурхай, уян хатан байх, харилцан мэдээлэл солилцох, төрийн болон албаны нууцыг хамгаалах зарчмыг баримтална.

2.3.Хөтөлбөрийг 2024 оноос 2027 оныг дуустал 4 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ.

ГУРАВ.ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Энэхүү хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Үндэсний аюулгүй байдлын хуульд нийцүүлэн дараах зорилтыг дэвшиүүлэв.

1. Оршин тогтонохын аюулгүй байдлыг хангах
2. Нийгэм-төрийн байгууллын аюулгүй байдлыг хангах
3. Иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдлыг хангах
4. Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах
5. Шинжлэх ухаан, технологи, мэдээллийн аюулгүй байдлыг хангах
6. Монгол соёл иргэншлийн аюулгүй байдлыг хангах
7. Хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг хангах
8. Экологийн аюулгүй байдлыг хангах
9. Хүнсний аюулгүй байдлыг хангах

3.1. Оршин тогтонохуйн аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд:

3.1.1.Төрийн батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг бүх шатны төр, захиргааны байгууллага, иргэдэд сурталчлах, ёсвөр үе, залуучуудад эх оронч үзэл хүмүүжил төлөвшүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах;

3.1.2.Аймгийн эдийн засаг, нийгмийн салбарын тогтвортой хөгжлийг хангахад гадаад харилцаа, хамтын ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор гадаад харилцаанд баримтлах бодлогыг хөгжүүлж, түүний зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэлийг зохицуулах;

3.1.3.Уламжлалт болон бусад шашин сүм хийдийн үйл ажиллагаа, шашны гаж буруу урсгал чиглэл нэвтрэх, сурталчлах, зүй тогтол бүрдэхээс урьдчилан сэргийлэх;

3.1.4.Гадаадын байгууллага, иргэн, хөрөнгө оруулалттай ААН, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих;

3.2.Нийгэм төрийн аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд:

3.2.1.Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг цахимжуулж, төрийн үйлчилгээг хялбаршуулан, төрийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгож, иргэдэд чирэгдэлгүй, хүнд сурталгүй үйлчлэх хүртээмжийг нэмэгдүүлэх;

3.2.2.Төрийн болон аж ахуйн нэгж байгууллагуудын авлигаас ангид байх манлайллыг нэмэгдүүлж, олон нийтийг соён гэгээрүүлэх замаар авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэн, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

3.2.3.Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих;

3.2.4.Нутаг дэвсгэрийн хэмжээнд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах, нийгмийн дэг журмыг бэхжүүлэх, хамгаалахад төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх;

3.2.5.Архидан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх, хүн амын удмын санд учрах сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр холбогдох ажлыг зохион байгуулах;

3.2.6.Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж, төр-иргэний нийгмийн хамтын ажиллагааны бүтээлч арга, хэлбэрүүдийг хөгжүүлэх;

3.2.7.Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус хэрэглээтэй тэмцэх.

3.3.Иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд

3.3.1.Нийгмийн эрүүл мэндийн байдал, өргөн тархалттай, шинэ болон сэргэж байгаа гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх;

3.3.2.Эм био бэлдмэлийн аюулгүй байдал, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалтад хяналт тавих;

3.3.3.Мансууруулах сэтгэцэд нөлөөт ургамал, эмийн бодисын хадгалалт, хууль бус хэрэглээг бууруулах, устгах ажлыг зохион байгуулах;

3.3.4.Боловсролын салбарт их, дээд, ерөнхий боловсролын сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, хүний хөгжлийг дээшлүүлэхэд анхаарах;

3.3.5.Иргэн бүр хуулийн өргөн мэдлэгтэй байхад чиглэсэн хуулийн сургалт, сурталчилгааг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа хэрэгжүүлэх;

3.3.6.Хорт хавдар болон бусад зонхилон тохиолдох халдварт бус өвчнийг эрт илрүүлж, оношлох, эмчлэх, осол гэмтэл, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийг бууруулахад анхаарч ажиллах;

3.3.7.Гамшиг, аюул, онцгой нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх дадлага туршлага олгох сургалт, үйл ажиллагааг тогтмол зохион байгуулна.

3.4.Эдийн засгийн аюулгүй байдлын хүрээнд:

3.4.1.Дотоод болон гадаад хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, үр дүнд тогтмол хяналт тавьж тулгамдаж буй асуудлыг цаг тухай бүрт нь шийдвэрлэх;

3.4.2.Байгалийн аюулт үзэгдэл, давагдашгүй хүчин зүйлс, газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, хот төлөвлөлт, барилга, байгууламж, орон сууцны гал тэсвэржилт болон газар хөдлөлтийн тэсвэржилтийн чанар стандартад хяналт тавих мөрдүүлэх, орон нутгийн гамшигтай тэмцэх чадвар, материаллаг орчин, техник зэвсэглэмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх;

3.4.3.Аймгийн хэмжээнд инженерийн шугам сүлжээ, дулаан, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх байгууллагуудын тоног төхөөрөмж байгууламжийн техник ашиглалтын найдвартай байдлыг хангаж ажиллах.

3.4.4.Иргэдийн татварын хууль тогтоомжийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулж, татварын ойлголт, хандлагыг сайжруулан, орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг жигд хангаж биелүүлэх;

3.4.5.Улсын болон аймгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж буй ажил, үйлчилгээний үр дүн, тулгамдаж буй асуудалд хяналт тавих;

3.4.6."Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хүдрийг дахин боловсруулах эцсийн бүтээгдэхүүн гаргах чиглэлд анхаарах;

3.4.7."Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын үйл ажиллагааг урт хугацаанд найдвартай, тогтвортой явуулахын тулд геологи хайгуул болон менежментийг сайжруулах;

3.4.8.Эрдэнэт хотыг үйлдвэрлэл аж ахуйн чиглэлийн хот болоход чиглэсэн олон талд арга хэмжээ авах, технологи, программ хангамжийн хөгжүүлэлтэд анхаарах;

3.4.9.Цахимаар үйлдэгддэг санхүүгийн залиах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн санхүүгийн суурь мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд төр хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах;

3.4.10.Аймгийн онцлогт нийцүүлэн гадаад болон дотоодод өрсөлдөх чадвартай бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих;

3.4.11.Ил тод, хариуцлагатай уул уурхай, эрдэс баялгийн салбарыг дэмжиж, түүнээс олох орлогыг ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн бие даасан хөгжлийг хангах, олон тулгуурт бүтцийг бий болгох, хүний хөгжлийг дэмжих, боловсрол, эрүүл мэнд, нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд зарцуулах.

3.5.Шинжлэх ухаан, технологи, мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд:

3.5.1.Цахим хэлбэрээр төрийн үйлчилгээ үзүүлж буй байдал, мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангахын тулд тоон гарын үсгийн аюулгүй байдал, цахим хуудасны эмзэг байдлыг бууруулах ;

3.5.2.Аймгийн харилцаа холбооны шугам дахь эмзэг байдал, өгөгдөл солилцооны хамгаалагдсан дэд бүтэц, утасгүй холбооны аюулгүй байдлыг хангах;

3.5.3.Мэдээллийн дэд бүтцэд халдах оролдлого үйлдлээс урьдчилан сэргийлэх, сургалт, сурталчилгааг зохион байгуулах, Мэдээллийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, эрсдэлийн талаар орон нутгийн удирдлага, иргэдийг үнэн, зөв мэдээллээр хангах;

3.5.4.Орчин үеийн техник, технологийн дэвшил хөгжлийн шинэ боломж олгохын зэрэгцээ нийгмийн бусад сөрөг үзэгдлүүдийн нэг болох "цахим" гэмт хэрэг ихээр үйлдэгдэж байгаад анхаарч иргэдийн эд хөрөнгө, алдар нэр, хувь хүний эмзэг мэдээллийн нууц, аюулгүй байдал, өдөр тутмын хэвийн үйл ажиллагаанд хууль бусаар халдаж буй нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, таслан зогсоох, олон нийтэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгаа, гэмт хэргийн нийгмийн хор уршигийн талаарх ойлголт хандлагыг төлөвшүүлэх;

3.5.5.Хэвлэл мэдээллийн байгууллага, хувь хүн, хуулийн этгээдийн зүгээс олон нийтийн сүлжээ болон бусад мэдээллийн сувгаар үндэсний аюулгүй байдалд харшилсан аливаа үйл ажиллагаа явуулахаас сэргийлэх;

3.5.6.Төрийн байгууллага болон Төрийн өмчид ААН, хуулийн этгээдэд чиглэсэн Төрийн болон албаны нууц мэдээ, мэдээлэл алдагдахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

3.5.7.Бэлчээрийн мал аж ахуй, малчдын ахуй амьдралд шинжлэх ухаан, технологийн ололтыг нэвтрүүлэх, уламжлалт сэтгэлгээ, арга хэвшлийг сэргээж, хурдацтай явагдаж байгаа экосистемийн өөрчлөлтийг мэдэрч түүнд тохирсон, дасан зохицсон амьдралын хэв маяг, аж ахуй эрхлэх менежментийн арга барилыг боловсруулж заан сургах, туршин нэвтрүүлэх, олон нийтэд хүргэх сургалт, сурталчилгааг явуулах;

3.5.8. Төрийн мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангахын тулд үнэн, бодитой, цаг үеэ олсон, шаардлагатай мэдээллийг төрийн мэдээллийн санд төвлөрүүлж, эрх бүхий этгээд хамтран ашиглах, солилцох нөхцөлийг бүрдүүлнэ.

3.6. Монгол соёл иргэншлийн аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд

3.6.1. Монголын түүх, хэл, соёл, зан заншил, уламжлалт шашин, соёлын биет болон биет бус өв, нутгийн онцлогтой язгуур өвийг хамгаалах, өвлөн уламжлуулах, бахархах үзэлд төлөвшүүлэх, сурталчлан түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

3.6.2. Монгол хэл, бичгийн соёлоо хамгаалан хөгжүүлж, уламжлалт монгол бичгийн сургалт сурталчилгааг өргөжүүлж, монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах;

3.6.3. Хүүхэд, залуучууд, иргэдэд ардын уламжлалт, арга ухаан, ёс, зан заншилаа танин мэдэж уламжлан өвлөх ажлыг зохион байгуулж, түүгээр дамжуулан эх оронч үндэсний үзлийг төлөвшүүлэх ажлыг нийгэм, гэр бүл, боловсролын тогтолцоогоор дамжуулан хэрэгжүүлнэ.

3.7. Хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд

3.7.1. Аймгийн хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийн чанарыг дээшлүүлэх

3.7.2. Гадаадын иргэд, харьялалгүй этгээдийн орон нутаг дахь бүртгэл, хяналтын чиглэлээр хийгдэж байгаа ажил, гарч буй сөрөг үзэгдэл, гадаадын иргэдтэй гэрлэгчдийн мэдээлэл, тандалт судалгаанд тухай бүр үнэлэлт өгч, зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3.7.3. Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар дундаж давхаргын хамрах хүрээг өргөжүүлэх;

3.7.4. Гадаадын хөрөнгө оруулалттай болоод гадаад иргэд авч ажиллуулж байгаа ААН байгууллагад хяналт тавих;

3.8. Экологийн аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд:

3.8.1. Усны нөөцийн хомсдолоос хамгаалах, ус хураах талбай, гол горхи булаг, шандын эхийг хамгаалах, мод бут тарих, голын урсац бүрэлдэх эхийг, орон нутгийн тусгай хамгаалалтад авах замаар байгалийн усны нөөцийг хамгаалж, нөхөн сэргээгдэх нөхцөлийг сайжруулах;

3.8.2. Бэлчээрийн даац, ургамлын бүрхэвчийн байдал, гарч байгаа өөрчлөлт, сөрөг, үзэгдэл, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах;

3.8.3. Хог хаягдал, орчны бохирдолт, эрүүл ахуйн бүс тогтоосон байдалд хяналт тавьж зохих арга хэмжээг авах;

3.8.4. Цагаан тоосны дэгдэлт, байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулахад анхаарч ажиллах;

3.8.5. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах чиглэлд иргэд модны суулгац бэлтгэж урвуулах түүнийгээ эдийн засгийн эргэлтэд оруулах боломжийг бий болгох;

3.8.6. Агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах

3.8.7. Ариун цэврийн байгууламжийн бүтээмжийг нэмэгдүүлж, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох,

3.8.8. Орон сууц, үйлдвэрлэл, үйлчилгээний барилга, инженерийн байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэрлэлтэд үнэлгээ өгч, 8 баллын газар хөдлөлтийг тэсвэрлэх шаардлага хангахгүй барилга, байгууламжид хяналт шалгалтыг хийж, дүгнэлт гарган, аюулгүй байдлыг хангана.

3.9.Хүнсний аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд

3.9.1.Хүнсний аюулгүй байдлын хяналтын арга хэмжээг өргөн хүрээнд хэрэгжүүлж, баталгаат байдлыг хангах,

3.9.2.Хүн амын хэрэгцээт мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн зэрэг гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг орон нутгийн үйлдвэрлэлээр хангах, шимт тэжээллэг чанарыг нэмэгдүүлэх, улирлын хамаарлыг бууруулах;

3.9.3.Төмс, хүнсний ногооны гарал үүслийг мешгөх тогтолцоог боловсронгуй болгох, төмс хүнсний ногоонд хлорорганик болон пестицид үлдэгдлийг тодорхойлж, ургамал хамгааллын хяналтыг сайжруулах;

3.9.4.Стратегийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийг баталгаажуулах , гамшигийн үед хэрэглэх гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх, хүн амыг хүнсний бүтээгдэхүүний эрэлтэд үндэслэсэн нийлүүлэлтийг тогтвортой хангахад анхаарах;

3.9.5.Хүн амыг ундны усаар хүртээмжтэй хангах, чанар, аюулгүй байдалд тавих хяналтыг өндөржүүлэх арга хэмжээ авна.

ДӨРӨВ.ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ХҮРЭХ ҮР ДҮН

4.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ.

4.1.1.Үндэсний аюулгүй байдлыг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг үр дүнгийн гүйцэтгэлээр нь 80-аас дээш хувьд хүргэх

4.1.2.Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд иргэд, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын идэвх, оролцоо, хамтын ажиллагаа нэмэгдсэн байх;

4.1.3.Үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй үйл ажиллагаандаа урьдчилан сэргийлэх, таслан зогсоо чадавхыг дээшлүүлж, эрсдэлийг бууруулж, хамтран ажиллах бэлэн байдлын түвшин дээшлэх;

4.1.4.Үндэсний аюулгүй байдлын зөвлөл тогтмол мэдээллээр хангагдах;

4.1.5.Хүн амын үндэсний аюулгүй байдлын талаарх мэдлэг, хандлага сайжирч, үндэсний аюулгүй байдлын баталгаа нэмэгдэх.

4.2 Хөтөлбөрийн үр дүнг доорх шалгуур үзүүлэлтээр хэмжинэ.

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2023 онд	Хүрэх түвшин 2024 онд	Хүрэх түвшин 2025 онд	Хүрэх түвшин 2026 онд	Хүрэх түвшин 2027 онд
1	Үндэсний аюулгүй байдлыг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг үр дүнгийн гүйцэтгэлээр нь 80-аас дээш хувьд хүргэх	9 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 57 арга хэмжээний хэрэгжилтийн хувь	хувь	50%	60%	70%	75%	80-аас дээш хувьд хүргэх

2	Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд иргэд, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын идэвх, оролцоо, хамтын ажиллагаа нэмэгдүүлэх	Хамтран ажилласан иргэний нийгмийн байгууллагын тоо	тоо	2	3	4	4	4
3	Үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй үйл ажиллагаандаа урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг дээшлүүлж, эрсдэлийг бууруулж, хамтран ажиллах бэлэн байдлын түвшин дээшлүүлэх	Хамтран зохион байгуулсан арга хэмжээний тоо	тоо	1	2	2	2	2
4	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тогтмол мэдээллээр хангах	Жилд мэдээлэл хүргүүлсэн тоо	тоо	2	2	2	2	2
5	Хүн амын үндэсний аюулгүй байдлын талаарх мэдлэг, хандлага сайжирч,	Сургалт сурталчилгааны ажлын тоо	тоо	2	4	6	8	10

	үндэсний аюулгүй байдлын баталгааг нэмэгдүүлэх						
--	--	--	--	--	--	--	--

ТАВ.ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ САНХҮҮЖИЛТ

- 5.1. Улс болон орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө
- 5.2. Олон улсын байгууллага болон төсөл хөтөлбөрийн санхүүжилт
- 5.3. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн хандив, тусlam
- 5.4. Бусад эх үүсвэр

ЗУРГАА.ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

6.1. Нутгийн өөрөө удирдах байгууллага хөтөлбөрийн биелэлтэд хяналт тавьж ажиллана.

6.2. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах байнгын ажиллагаатай ажлын хэсэгтэй байна. Ажлын хэсгийн дарга нь Аймгийн Засаг дарга, нарийн бичгийн дарга нь Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга байна.

6.3. Аймгийн Засаг дарга нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах үүрэгтэй бөгөөд нутаг дэвсгэрийн хэмжээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган өдөр тутмын удирдлага, зохион байгуулалтаар хангаж, төрийн тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудад чиглэл өгч, үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, таслан зогсох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээ авч, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд орон нутагт тулгамдаж буй асуудлаар илтгэлийг боловсруулан танилцуулж, хууль тогтоомжид заасан бусад мэдээ, мэдээллийн талаар санал, хүсэлт гаргах, шийдвэрлүүлэх зэрэг үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

6.4. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах байнгын ажиллагаатай ажлын хэсгийн гишүүд, тусгайлсан чиг үүрэгтэй байгууллага, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

6.5. Аймгийн Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, албад болон сумдын Засаг дарга нарын аймгийн Засаг даргатай байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх заалтыг тусгана.

ДОЛОО.ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ТАЙЛАГНАЛ

7.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг жил тутамд аймгийн ИТХ-ын зөвлөлд тайлagnana.

7.2. Хөтөлбөрийн хэрэгжилт. үр дүнг тооцож 2 жил тутамд тухайн жилийн 4 дүгээр улиралд аймгийн ИТХ-д оруулж хэлэлцүүлэх.

7.3. Мэргэжлийн байгууллагаар хөтөлбөрийг хөндлөнгийн хяналт, үнэлгээг 2 жил тутамд хийлгэж болно.

7.4.Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээнд үндэслэн шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж батлуулна.

-- 000 --